



ЛАМБУГАЙН НУЛИМС


ДАШДОРЖИЙН НАЦАГДОРЖ

Хичээлийн зорилт

- Зохиолыг сайтар унших
- Зохиолд гарсан дүрүүдийн талаар ярилцах, задлал хийх
- “Ламбугайн нулимс” нулимс зохиолтой төстэй зохиол байдаг эсэхийг мэдэх
- Д.Нацагдорж зохиолдоо юуг тусгахыг зорьсон, зохиолын гол санааг тодорхойлох

ГЭВШ ЛОДОН

- Винайн ёсыг сахисан...
- Орчлон ертөнцийг хоосон гэж хүрдийг бясалгаж...
- Улаан шарыг тунуулсаар...
- Гандангийн наад хүр рүү бууж ирмэгц...
- ГЭВШ ЛОДОН...



Орчлон ертөнцийг хоосон гэж хүрдийг бясалгаж...

“Ертөнцийн юм бүгд хоосон чанартай учир амьдралд шунах нь утгагүй бөгөөд хамаг амьтан тэнгэр, асар, хүн, адгуус, бирд, там хэмээх зургаан зүйл амьдралын хүрдэнд үйлийн үрээр эргэлдэж байдаг, зөвхөн хоосон чанарыг таньж буян үйлдсэнээр бурхан болж болно” гэсэн буддын шашны үндсэн номлол юм.

Винайн ёсыг сахиж...

Винайн ёс гэдэг нь буддын шашны лам нарын дагаж явах сахио санваар, ёс журам бөгөөд гэлэн хүн 253 төрлийн сахилыг дагаж явах ёстой ажээ.

ГЭВШ

Буяны садан гэсэн утгатай төвөд үг. Богд багш буюу дээд ариун багш гэсэн утгатай бөгөөд хүслийн нисванисыг тэвчиж, ариун ёсыг сахиж, гэм бүхнээ арилгаж, эрдэм бүхнээ дэлгэрүүлэх төгс хичээлийн зам мөрт эргэлт буцалтгүй орсон ламын мяндаг.

Лодон- Оюун төгөлдөр гэсэн утгат төвөд нэр

Улаан шарыг тунуулсаар...

Улаан шар орхимж нь буддын шашны ёсны номт хувцас төдийгүй Лодонгийн тайван амгалан дүр төрх, сэтгэлийн амгаланг нэгэн зэрэг харуулж байна.

Гандангийн наад хүр рүү бууж ирмэгц...

Гандан гэдэг нь Төгс
баясгалант гэсэн
утгатай хийдийн нэр
бөгөөд мөн нэгэн
зүйлийн бурхны
орны нэр юм.



Иүй Бай Хуа буюу Цэрэнлхам

- Урин тачаангуйн хурц илдийг боловсруулахын илдийг судалсан...
- Иүй Бай Хуа – Цагаан хас чулуу гэсэн утгатай хятад нэр
- Хар цагааныг гялбалзуулсаар...
- Баруун дамнуурчны шавартай гудамжнаас гарч ирэх нь...



Утгын тайлбар

- **Урин тачаангуйн хурц илдийг боловсруулахын илдийг судалсан** - Дууч эмсийн хүний сэтгэл татах эрдэмд боловсорсон
- **Иүй Бай Хуа** – Тухайн үеийн Хүрээний хөнгөн явдалт хүүхнүүд хятад нэр авдаг байжээ.
- **Хар цагааныг гялбалзуулсаар** – Хар цагаан өнгө нь ертөнцийн сайн муут бэлгэдэх бөгөөд энд Цэрэнлхам хүүхний бусдаас содон байдал төрх, явдал учрыг тодруулан харуулжээ.

Утгын тайлбар

○ Баруун дамнуурчны шавартай гудамжнаас гарч ирэх нь — Баруун дамнуурчны гудамж нь тухайн үеийн хотын хятад хороолол



◦ Иүй Бай Хуагийн хар тамхи тасарсан учир нэг алтан бөлзгийг бариулж, хэдэн янчаан олж хэрэглэхийг зорьж явсан нь санамсаргүй гэвш Лодон тохиолдохыг үзвэл тэр үнэхээрийн нэг томхон хувраг бөгөөд сэтгэл зөөлөн, чанар хөнгөн болохыг хэдийнээ ажиглан таниад, цахилгаан мэт хурдан нэг аргыг олж, хуялын сэтгэл өдөгдөж, ламын дэргэд зогсож, зовлонтой бөгөөд бахардсан царай гарган, “Ламбугай өршөө. Манай хөгшин эх өвдөөд, үхэхийг хүлээж байнам. Хичээж манайд морилж, ном айлдаж хайрлана уу” гэсэнд

...лам “Зүүн хүрээнд хуралд очиж явна. Энэ удаа амжихгүй. Өөр нэг ламыг залсугай” гэсэн боловч Иүй Бай Хуа сандарсан байдлыг гаргаж, дахин давтан зовлонг үгсийг тоочин, элдэвчлэн гуйхад аргагүй болж бас ч бахардсан байдлыг үзвэл “Барьц ихээхэн өгөх биз” хэмээн санаж, ном уншихаар хүүхнийг дагалдан, түүний гэрийн зүг одов.

Шуналын
сэтгэл
өдөгдөж

Гадаад биеийн
ялгаа, дотоод
сэтгэлийн чанар
огтхон ч ялгарах
юмгүй болж...

Хучлын сэтгэл
өдөгдөж

Дайн

Зуны цагт баруун дамнуурчны таван гудамжны шавар Үлэмж, баасны Үнэр ханхлах нь Үнэхээр **ТҮМЭН багц хүжийг нэгэн зэрэг шатаавч Үл дарагдмаар...**

Гэвч Лодон орхимжоороо хамраа бөглөн, хүүхний хойноос **намс намс алхална**. Удалгүй нэг хувхай цагаан хаалгаар орвол гангийн арьс ширийн шорвог агаар амтагдаж, зүйлсэн Үс, ноос салхинд хийсэн, дээл хувцсанд наалдана.

Хоёр нурсан шавар байшингийн нарийхан завсраар өнгөрч, баруун талд зүүн тийшээ харсан шавар байшинд ороход хүүхэн ламыг нэг сандал дээр суулгаад, “Цай авчиръя” хэмээн гарч одохын завсар лам ажиглавал байшингийн өмнө этгээдэд нэг том ор байх бөгөөд хөнжил дэвсгэрийг цэмцийтэл хураан засаж, эрээн даавуугаар хучжээ. Хойд этгээдэд нэг бага дөрвөлжин ширээг цагаан даавуугаар бүтээж, дээр нь нэг том цаг ба зураг хөргийг тавьжээ.

Байшингийн дээвэр нь маш балтгар бөгөөд гэвш Лодон өндийвөл толгой нь бараг тулна. Нэг бага цонхыг хоёр давхар муутуугаар битүүлэн нааж, улаан цаасаао угалзлан чимжээ.

Байшингийн дотор өдөр байтлаа бүрий барайн байдлыг төрүүлнэ. Цонхны буланд нэг бяцхан нүхийг гаргасан бөгөөд бодвол орж гарах хүнийг ажигладаг бололтой.

Удалгүй хүүхэн орж ирээд, нэг аяга цай өгсний дараа “Ачит лам минь авралдаа тольдож, миний эхийг эдгээн соёрх” гэж гуйна. Лам хүүхний зүг ажиглавал гадна нарны гэрэлд түүний царай хувхай цагаанаар өнгөгүй үзэгдэж байсан нь харин энэ байшингийн дотор орж ирээд, **хоёр хацар нь улаанаар гэрэлтэж**, өглөөгүүр залбирдаг цагаан дара эхийн хөргийн адил үзэсгэлэнтэй гэрэлтэхэд ламын сэтгэлийн дотор **ертөнцийн манан бяцхан пур пураар үүсэх бөгөөд**

...их л эелдэг зантайгаар “За бүсгүй ээ, ижий чинь хаана вэ?” гэж асуувал хүүхэн энэ завсар эхээ нэгэнт хуурамчаар хэвтүүлсэн тул “Энд байгаа” гэж ламыг дагуулан оруулсан бөгөөд нэг настай хөгшин хөнжлөөр хучаастай хэвтэж байна. Хоймор нь нэгэн бяцхан гүнгэрваатай бурхан их л шороо тоосонд дарагдсан үзэгдэх бөгөөд өмнө нь хятад янзаар хоёр улаан лаа хатган тавьжээ. Түүнээс лам ном уншиж, залбирал даатгал хийснийг өгүүлэх юун.

Ном уншиж сая барвал нэгэнт шӨНӨ орой болжээ. Эх нэлээд сэргэсэн байдалтай бурхан ламын аврал гэж залбирна. Хүүхэн нэгэн адил ламд сүсэг төрсөн байдлыг гарган, хажуугаар нь **ҮГ ХЭЛЭХ** ба инээн аашлах нь их л бахтай.

Хоёр хар нүдээ жирвэгнүүлэн эргэлдүүлэх бүрд Лодонгийн сэтгэлд **бяцхан ширүүн гал ноцон ноцон алдана.**

Хүүхэн нэгэнт энэ байдлыг мэдсэн тул
“Ламбугай орой болсон тул миний гэрт хоол
зооглоод морилно уу” гэсэнд лам нэгдүгээрт бяцхан
ядарсан ба хоёрдугаарт ном уншсаны хойно хоол
идээд явдаг нь лам нарын тогтсон заншил тул даруй
зөвшөөрч нөгөө байшинд хүүхнийг дагалдан оров.

ХҮҮХЭН ТОГООЧОО дуудан, хоол бэлтгүүлж
ламыг зочилсноос гадна энэ үед хүүхний өдөл нь
улам улам илүү болж, **шадарлах нь нэн ойр тулав.**

Ийн тийн ярилцсаар, ламын **ертөнцийг**
сайшаах сэтгэл нь улам нэмэгдэж, нэг үдшийн зуур
Дуйнхарын аймаг дахь дөрвөн ханатай гэр ба хэдэн
гүнгэрваатай бурхнаа маржээ.

Түүнээс хүүхэн “Өнөө нэгэнт орой болсон бөгөөд бидэнд таныг хүргэн өгөх уналгагүйгээс гадна бас бороо орж байгаа тул энэ шөнө энд морилж хоноод, маргааш харивал сайн биш үү?” гэсэнд лам хойш нэгэнтээ бодсон боловч үнэхээр орой болж, бороо орж байгаа, мөн ч энд баахан зугаатай болох тул энэ шөнө дороо хонохыг нэгэнт шийдэв.

Хүүхэн баясаж, дэр дэвсгэрийг засав. Тус тусын
ор дэвсгэр дээр унтсан хойно мэдээжийн хэрэг
хүүхэн **хааяа хааяа зӨӨЛӨН ханиана**. Ламын нойр Үл
хүрнэ. Лам хэдийгээр **хүүхэнд халдахыг хүсэвч**
угаас эхнэр хүүхэдтэй төдий л ихэд холилдсонгүй
тул баахан халширна. Лам тэсэж ядахдаа шээнэ гэж
шалтгаалан босож, эргэж ирэхдээ хүүхний өвөрт
оръё гэж сэтгэж, гадаа гарч одов. Удалгүй эргэж
ирээд, гадна чагнавал чив чимээгүй, хаалгыг татвал

“Ламбугай бяцхан байзнаарай” гэж хүүхэн
өгүүлэхэд лам юу болохыг хүлцэж ядан, долоовор
хуруугаа норгож, байшингийн цаасан цаасан
цонхыг цоолоод, мөнхүү бяцхан нүхээр ажиглавал
хүүхэн хөнжил дээрээ дотуур хувцсаа тайлж байх нь
дэнгийн гэрэлд үзэсгэлэнтэй үзэгдэж, сэтгэлийг
хөдөлгөхөд дамын хоосон чанарын бодлогоо
хэдийнээ нөгөө ертөнцөд шилжиж, вилайн ёс
нэгэнт баруун зууд очоод, тачаангуйн гал дүрэлзэн
бадрахад яаран орж, хүүхний хамт нойрсов.

Түүнээс ертөнцийн хэрэг ламын сэтгэлд тааламжтайг тоочвол барахгүй. Даруй өглөө харьсан боловч үдэш санагдан, эргэж ирсээр нэгэнт хэд хэдэн сар болж, баруун дамнуурчны ба гандангийн дэнж хоёрын хооронд нэг нарийхан шинэ зам нээгдэв.

Түүнээс Иүй Бай Хуа Лодонд үнэхээр дурласан бус тул энэ завсар баян гэвшийн буянгаар дэмий л тарвалзсан боловч бас ханахгүй. Гэвш Лодон ертөнцийн цаламд нэгэнт урхилагдаж, хүүхний арга зальд автагдаад юу гэвч гажуугүй болсон бөгөөд яван явсаар лам гандан дахь хашаа байшин ба гавж болохын тулд бэлтгэсэн юмаа бүгдийг нийлүүлж, Иүй Бай Хуад гуа сайхан элбэг дэлбэг хашаа байшин төхөөрч, хорооны газар хамтран суух болов.

Нэг өдөр гэвш Лодон гэртээ ирээд байшингийн хаалгаа татвал дотроос түүгжжээ. Цонхны булангийн завсраар үзвэл Иүй Бай Хуа нэг залуу хар хүнтэй тэврэлдэн сууна. Иүй Бай Хуагийн хуучны зузаан янаг бий гэсэн нь энэ мөн байна гэж лам нэгэнт таниад, уур нь бадарч занчилъя гэж байшингийн хаалгыг хэмх цохин орж, хэрүүл шуугиан гаргав.

Гэтэл хүүхэн өчүүхэн ч эмээх зовор байдалгүй бөгөөд харин ламд дургүй учрыг хэлж, хараан загнаж, хөөн гаргасанд лам заалдъя гэвч хуврагийн ёсоо эвдсэн тул аргагүй гунихран, байшингийн босгыг нь тэвэрч, “Хүү минь, би чамд хайртай. Одоо би хаашаа очих вэ? Өөр хүнтэй ханилах хамаагүй. Гагцхүү намайг бүү орхи” хэмээн хоёр нүднээсээ ертөнцийн хар нулимсыг борооны дусал адил асгаруулна.



Ертөнцийн хар нулимс

- Ертөнцийн манан бяцхан пур пураар үүссэн
- **Ертөнцийг сайшаах сэтгэл нэмэгдсэн**
- Ертөнцийн хэрэг сэтгэлд тааламжтай
- Ертөнцийн цаламд нэгэнт урхилагдаж

Ламбугайн нулимс

ЭМГЭНЭЛТ

ХОШИН

Зохиолын тухай шүүмж

Энэхүү өгүүллэгийг монгол судлаач эрдэмтэн Л.К.Герасимович “Энэ хорвоогийн харын бүх юм хоосон мөнх бус болохыг номлон байдаг атлаа хөнгөмсөг явдалт хүүхэнд сэтгэлтэй болсон ламыг дооглог шоолсон” гэж тодорхойлсон бол монголын эрдэмтэн Ч.Лодойдамба “Лодон бол үлэмж хүчтэй эмгэнэлт дүр, Нацагдорж Лодонг огт шоолоогүй, харин амьдралд тохиолдсон эмгэлэгт явдлыг үзүүлсэн юм.” “Нацагдоржийн энэ зохиол нь эмгэнэлт зохиол мөн” гэж тодорхойлжээ.

Та нар Лодон гэвхийг өрөвдөж байна уу?

Эсвэл шоолж байна уу? Яагаад?

Гэрийн даалгавар

- Зохиолын үйл явдлыг өнөөгийн нийгмийн байдалд буулган бичиж ирэх.
- Уг зохиолтой төсөөтэй өөр ямар ямар зохиол байдгийг мэдэж ирэх.